



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 4/117

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дүгээр зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх “Ховд дулааны станцын аваарын нөөц бүрдүүлэлт” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Б.Батсүх	- Худалдан авах ажиллагааны албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
--------	----------	--

Гишүүд:	Ж.Энхтайван	- Жаргалант сумын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
---------	-------------	---

Э.Нямдорж	- Иргэний төлөөлөл
-----------	--------------------

Б.Загджүсэм	- Төрийн бус байгууллагын төлөөлөл
-------------	------------------------------------

Нарийн бичгийн

дарга:	Д.Дариймаа	- Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн
--------	------------	--

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж, үр дүнг танилцуулахыг үнэлгээний хорооны дарга /Б.Батсүх/-д даалгасугай.

3. Дээрхи төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн хадгалахыг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Д.Дариймаа/-д үүрэг болгосугай.



ДАРГА

Д.ЭНХБОЛД

Туш А/117 Кн